



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/30

Шивээговь сум

Малчдад цол тэмдэг, батламж
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5, "Сумын Засаг даргаас олгох шагналын журам"-ын 2.4, 3.1.4, 5.6, сумын Засаг даргын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Эрдэнэт мал сүргийнхээ тоо толгой өсгөж, малын ашиг шимийн гарц, чанар, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, сумын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг үнэлж сумын "Аварга малчин өрх"-өөр Шивээговь сумын 2 дугаар багийн малчин Шараагийн Мөнхбаясгалан, Доёдын Нансалмаа, Балжиннямын Эрдэнэбаатар, Мэндбаярын Пүрэвсүрэн, Дэмбэрэлийн Лхагвасүрэн, Тамжавын Цэнддоо нарыг, сумын "Алдарт уяач"-аар Жамбалын Эрдэнэхүү нарыг шалгаруулж цол, тэмдгийг тус тус олгосугай.

2.Аймгийн "Аварга малчин өрх"-өөр шалгарсан Төмөрбаатарын Баттөмөр, Төмөртоогоогийн Отгондүү нарт хүндэтгэл үзүүлэн, дурсгалын үнэ бүхий зүйлээр урамшуулсугай.

3.Шагнал, урамшуулалд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.


4.Шагналд зарцуулагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зохих журмын дагуу гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал), Ахлах нягтлан бодогч (Л.Туяа) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2024 оны 02-р сарын
05-ны өдрийн 1120 дугаар
захирамжийн ...-р хавсралт



СУМЫН АВАРГА МАЛЧИН ӨРХ, АЛДАРТ УЯАЧ,
АЙМГИЙН АВАРГА МАЛЧИН ӨРХӨД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2024.02.05

№	Бүтээгдэхүүний нэрс	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Сумын "Аварга малчин" малгай	ширхэг	300,000	3	900,000
2	Сумын "Аварга малчин өрх"-д саалийн хувин	ширхэг	170,000	3	510,000
3	Сумын "Аварга малчин өрх"-д өргөмжлөл	ширхэг	40,000	3	120,000
4	Дагалдах мөнгөн шагнал Сумын "Аварга малчин өрх"	өрх	200,000	3	600,000
5	Сумын "Алдарт уяач" тэмдэг, үнэмлэх	багц	100,000	1	100,000
6	Дагалдах мөнгөн шагнал Сумын "Алдарт уяач"	ширхэг	100,000	1	100,000
7	Аймгийн "Аварга малчин өрх"-д хүндэтгэл үзүүлэх	ширхэг	320,000	1	320,000
8	"Алтан төлийн эзэн"-д хүндэтгэл үзүүлэх	ширхэг	350,000	1	350,000
Нийт дүн					3,000,000